



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2009 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 337.

Улаанбаатар хот

Г Тушаалд өөрчлөлт оруулах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Гадаадад зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 375 дугаар тушаалын Чинбатын Нарбилэгтэй холбогдолтой хэсгийн суралцах хугацааг “1 жил” гэснийг “3 жил” гэж, “Гадаадад зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 370 дугаар тушаалын Эрдэнэбилэгийн Гантулгатай холбогдолтой хэсгийн суралцах хугацааг “2 жил” гэснийг “3 жил”, “Гадаадад суралцуулах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 276 дугаар тушаалын Ноовын Мөнхтуяатай холбогдолтой хэсгийн суралцах хугацааг “1,5 жил” гэснийг “2 жил”, “Гадаадад зээлээр суралцуулах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 268 дугаар тушаалын Лхагвадоржийн Өнөртэй холбогдолтой хэсгийн суралцах хугацааг “1 жил” гэснийг “2 жил” болгож тус тус өөрчилсүгэй.

2. “Гадаадад зээлээр суралцуулах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 427 дугаар тушаалын Нямсүрэнгийн Даваанямтай холбогдолтой хэсгийн “Англи улсын Лейкстер коллежийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр” гэснийг “Англи улсын CECOS коллежийн магистрантурт хуулийн чиглэлээр” гэж, мөн “Гадаадад зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 351 дүгээр тушаалын Хоролсүрэнгийн Ундраатай холбогдолтой хэсгийн “АНУ-ын Колорадогийн их сургууль” гэснийг “АНУ-ын Колорадогийн техникийн их сургууль” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



*(Handwritten signature)*

Ё.ОТГОНБАЯР